



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/914

Өлгий

Газар эзэмших эрхийн дуудлага цахим
дуудлага худалдаа зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 3.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 126 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлгий сумын 11 дүгээр багийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээний зориулалтаар олгох 32 м² газрын дуудлага худалдааг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны анхны үнийг 240000 /хоёр зуун дөчин мянган/ төгрөгөөр, дэнчингийн үнийг 24000 /хорин дөрвөн мянган/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

3. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг захирамж гарсан өдрөөс эхлэн 30-аас доошгүй хоног олон нийтэд, ил тод мэдээлэн зарлаж, дуудлага худалдаа бэлтгэл ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /К.Болат/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАУЫРЖАН

.. 0101220621

2104.09 13:21:46, A4 210 x 297 mm

БАТЛАВ: БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Х. АСХАР

ӨЛГИЙ СУМЫН 11-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРЭЭС ХУДАЛДАА НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ДУУДЛАГА
ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШЛЫН СХЕМ
МАСШТАБ 1:500



